

НИЙТИЙН СОНСГОЛЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 12 дугаар сарын 24

Налайх дүүрэг

Хурлыг: 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 14:00 цагт Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба зохион байгуулж, ИТХ-ын Төлөөлөгч, Засаг даргын орлогч Х.Анхбаяр даргалав.

Хуралдаанд оролцсон: Дүүргийн 1-8 дугаар хорооны нийт 33 иргэн оролцов. “Бүхнийг боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл” ашгийн бус төрийн бус байгууллагын тэргүүн Д.Тунгалаг, Бүхнийг боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл” ашгийн бус төрийн бус байгууллагын Налайх дахь салбарын зохицуулагч Б.Ардак, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичиг бөгөөд Ажлын албаны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Ганцэцэг, ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Ялалт, Боловсролын хэлтсийн дарга Д.Отгонжаргал, Насан туршийн боловсролын төвийн дарга Б.Жавзандулам, ЭМТ-ийн дарга Л.Байгал, ИТХ-ын Ажлын албаны албан хаагчид нар оролцов.

Нийтийн сонсголын сэдэв: Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр тусгасан асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулах

Хэлэлцсэн асуудал:

- Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах, нийгэм сэтгэлзүй, эрүүл мэнд, дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлэх талаар ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Ялалт танилцуулав.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалтын талаар Боловсролын хэлтсийн мэргэжилтэн М.Нандинцэцэг

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурахад тулгардаг хүндрэлтэй асуудлууд, давуу болон сул тал, боломж нөхцлийн талаар Насан туршийн боловсролын төвийн дарга Б.Жавзандулам танилцуулав.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний чанар хүртээмжийн талаар ЭМТ-ийн дарга Л.Байгал танилцуулав.

Сонссон нь:

Сонсгол даргалагч Х.Анхбаяр- Нийтийн сонсголын дотоод журмыг уншиж танилцуулав. Дараах асуудлыг хэлэлцэнэ. /Нийтийн сонсголын дотоод журмыг хавсаргав./

- Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах, нийгэм сэтгэлзүй, эрүүл мэнд, дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлэх талаар ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Ялалт танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав./

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалтын талаар Боловсролын хэлтсийн мэргэжилтэн М.Нандинцэцэг танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав./

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурахад тулгардаг хүндрэлтэй асуудлууд, давуу болон сул тал, боломж нөхцөлийн талаар Насан туршийн боловсролын төвийн дарга Б.Жавзандулам танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав./

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний чанар хүртээмжийн талаар ЭМТ-ийн дарга Л.Байгал танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав./

Сонсгол даргалагч Х.Анхбаяр- Нийтдээ 5 илтгэл та бүхэн сонслоо. Хэлэлцэж буй асуудлаар асуулт, саналтай иргэн байна уу?

Иргэн Д.Бямбасүрэн - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолой болно гэдэг нь албаны журмаар амархан хэрэгжүүлдэг ажил биш юм. Тэдний дуу хоолойг сонсож, тэднийг ойлгох хэрэгтэй болно. Налайх дүүрэгт христийн чуулганы хамтын ажиллагааны баг гэж байдаг. Сүүлийн 2-3 жилийн хугацаанд 200 гаруй хүүхдүүдэд тогтмол бэлэг өгч оролцож байна. Дүүргийн хэмжээнд төрийн байгууллага сүүлийн 4 жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү хандсан, хүн руу хандсан олон үйл ажиллагаа зохион байгуулагдаж, ажил сайн явж байна гэж дүгнэж байна. Би хүүхдийн төлөө цохилох зүрх болгонд, хүүхдэд хайртай, ээлтэй “Хайрын хотхон” байгуулах хүсэл, зорилготой байдаг. Та бүхэн минь дэмжээрэй. Гаднаас орж ирж байгаа ашгийн бус байгууллагын тусламж, үйлчилгээг авах хэрэгтэй.

Иргэн Д.Март – Би тархины саажилттай 14 настай хүүхэдтэй. Манай хүүхэд гэрээр сургуулийн боловсролыг авч байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан сургалтын чанар, үнэлгээг сайжруулах, үнэлгээ өгч, боловсролын гэрчилгээ, батламж өгдөг байх хэрэгтэй байна. Хөгжлийн цогц үйлчилгээ гэж яригдаж байна. Үүнийг бодлогын түвшинд, байгууллага болгонд уялдуулж, үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эмнэлгийн тусламж, үйлчилгээг очиж авахад хүндрэлтэй байдаг тул орчин нөхцөлийг сайжруулах хэрэгтэй байна. Эмнэлгийн 2 давхарт том болсон хүүхдээ өргөж гаргахад маш хэцүү байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шүдийг гэрээр эмчлэх боломж байна уу? Очоод үзүүлэх гэхээр оочир, дараалал нь дуусчихсан үзүүлж чадахгүй байна.

Засаг даргын орлогч Х.Анхбаяр – иргэн Д.Мартын асуултад хариулъя. Гэрт хүргэх үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шүдийг эмчлэх нь боломжгүй

юм. Учир нь гэрийн нөхцөлд хийх боломжгүй, заавал эмнэлгийн нөхцөлд хийх мэс ажилбар юм. Үүнийг гэрээр үйлчлэх нь халдвар, хамгаалал алдах эрсдэлтэй учир мэргэжлийн хяналтаас хориглосон. Гэрээр хүргэх үйлчилгээг энэ онд 200 иргэнд үйлчилсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хороодтойгоо уялдаатай харилцаж, гэрийн үйлчилгээгээ авах хэрэгтэй.

Боловсролын хэлтсийн мэргэжилтэн М.Нандинцэцэг – иргэн Д.Мартын асуултад хариулъя. Ерөнхий боловсролын сургалтын үнэлгээний асуудал зөвхөн Монголд гэлтгүй дэлхий дахинд тулгамдсан асуудал байдаг. 2018 онд Сайдын 425 дугаар тушаалаар үнэлгээний журам батлагдсан. Энэ журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ахицаар нь үнэлнэ гэж заасан. Албан бус насан туршийн боловсролын багш нар маань хүүхдүүдийн төвшингөөс хамаарч үнэлгээг өгч, төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа.

ЭМТ-ийн дарга Л.Байгаль – иргэн Д.Мартын асуултад хариулъя. Гэрт хүргэх үйлчилгээг үзүүлэхдээ өрхийн эрүүл мэндийн төвөөс иргэдийн судалгааг авч, судалгааны үндсэн дээр эмчийн баг томилон бүх шинжилгээг гэрээр хүрч авдаг. Үзлэг, үйлчилгээ явагдсны дараа 7 хоногт 1 удаа сувилагч нарын баг очин эмчилгээг хийж, сард 4 удаагийн давталттай үздэг. Шаардлагатай гэж үзвэл өдрийн эмчилгээг явуулж байна. Тийм учир иргэд хороодтойгоо сайн харилцаж, мэдээлэлээ өгдөг байх хэрэгтэй. Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилга хуучин 1984 онд баригдсан, стандарт бус барилга учир хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам, шат тавих боломжгүй юм. Тийм учир налуу шат, бариул, тасаг бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүрч үйлчлэхээр ажиллаж байна.


Иргэн О.Батхуяг – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хичээлдээ явахад хүндрэлтэй байна. Алслагдсан хороонд, алслагдсан гэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан автобус шийдэж өгнө үү. Төрийн үйлчилгээ авах эрхийг хангах хэрэгтэй байна. Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, судалгааг бодитой гаргах хэрэгтэй. Учир нь дүүргийн ерөнхий боловсролын сургуульд сурах боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдүүд хот руу явж боловсрол эзэмшдэг. Тэдний сурч боловсрох, эрхийг хангахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зөөх сургуулийн автобусыг шийдэж өгнө үү.

Засаг даргын орлогч Х.Анхбаяр – Иргэн О.Батхуягийн асуултад хариулъя. “Голомт” цогцолбор сургуулиас бусад бүх сургуулиуд сурагчдын автобустай болсон. Явган замын хувьд 8 чиглэлийн 3,5 км зам тавигдсан. 320 сая төгрөгийн өртөг бүхий явган зам тавигдсан.

Иргэн Д.Тунгалаг – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, төрийн үйлчилгээг нь сайжруулахад дотоод нөөц бололцоог ашиглан эцэг эхчүүдийг сургах үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт байхаас нь эхлүүлээд анхаарал хандуулж ажиллаачээ гэсэн санал хэлмээр байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх статистик тоон

мэдээний зөрүүг арилгахад анхаарч хоорондын уялдаа холбоотой ажиллаачээ гэсэн санал тавьж байна.

Сонсгол даргалагч Х.Анхбаяр – Өөр асуулт асуух, санал хэлэх иргэн байхгүй тул өнөөдрийн нийтийн сонсголын хуралдаан албан ёсоор хаасныг мэдэгдье. Хурал 17 цаг 05 минутад өндөрлөв.

ХЯНАСАН: ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  А.ГАНЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ХУРАЛДААН, ХУРЛЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР
ГАДААД ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
 П.БАДАМХАНД